



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАР**

**БУЛГАН АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН
ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2017 ОНЫ ЖИЛИЙН
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ, САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

**Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харицана уу.**

**Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор
Д.Анхбаяр
Утас: 70342580**

**Хавсралт 1: Менежментийн захидал
Хавсралт 2: Аудит хийсэн санхүүгийн тайлан**

**Хавсралт 3: Төсвийн гүйцэтгэлийн тайлан
Хавсралт 4: Акт, албан шаардлага
Хавсралт 5: Алдаа зөрчлийн нэгтгэл**

**Аудитын менежер
Ж.Энхцоодол
Утас: 70342716**

**Ахлах аудитор П.Содном
Утас: 70342495
Ахлах аудитор Г.Намчинсүрэн
Аудитор Д.Даариймаа
А.Сувдаа
Гэрээт ажилтан З.Ганбаатар
Х.Баттулга**

**Хаяг : Аймгийн ЗДТГ-ын байр
403 тоот**

Агуулга

Аудитын гэрчилгээ	2
1.1 Аудит хийх үндэслэл, хугацаа.....	4
1.2 Аудитын зорилт, хамарсан хүрээ.....	4
1.3 Аудитын арга зүй.....	4
1.4 Баримталсан бодлого, аргачлал.....	5
2. Санхүүгийн дотоод хяналт.....	5
3. Шилэн данс.....	6
4. материаллаг байдлын түвшин.....	6
5.Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар	
5.1 Мөнгөн хөрөнгө, бүртгэл тайлагнал	7
5.2 авлагын бүртгэл, тайлагнал.....	9
5.3 Бараа материалын бүртгэл, тайлагнал.....	12
5.4 Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагнал	14
5.5 Өр төлбөрийн бүртгэл, тайлагнал	18
5.6 Орлогын бүртгэл, тайлагнал.....	20
5.7 Зардлын бүртгэл, тайлагнал.....	23
6. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	31
7. Аудитын дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	31

ТОВЧИЛСОН ҮГС

ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ОНААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТАБ	Төрийн аудитын байгууллага
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ОНТБ	Орон нутгийн төсвийн байгууллага
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТЗС	Тусгай зориулалтын сан
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
БХС	Байгаль хамгаалах сан
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
НББ	Нягтлан бодох бүртгэл
СХС	Сум хөгжүүлэх сан

Нэг. Оршил:

Энэхүү тайланд үйлчилүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илэрүүлсэн гол зүйлс, гарсан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулагдаагүй материаллаг биш алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

1.1. Аудит хийсэн үндэслэл, хугацаа:

Төсвийн тухай хуулийн 8.9.4, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1-д заасан Булган аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн дагуу Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйл, МУ-ын Ерөнхий аудиторын 2018 оны А/05 тушаалыг үндэслэн Булган аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд БУА- 2017-/01/СТА-ТЕЗ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай зэрэг хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсны стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

1.2. Аудитын зорилт, хамарсан хүрээ:

Булган аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсны Секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/ болон бусад заавар журмын дагуу бэлтгэж, ажил гүйлгээ нь түүнийг зохицуулж буй хууль, тогтоомжийн хүрээнд хийгдэж үнэн шударга илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаагаар ханган дүгнэлт өгөхөд энэхүү аудитын зорилт чиглэгдлээ.

Булган аймаг дахь Төрийн аудитын газар Булган аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж, санал дүгнэлт гаргахын өмнө Төсвийн тухай болон Төрийн аудитын тухай хуулийн дагуу төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд тайлангаа нэгтгүүлдэг байгууллагуудын санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргасан болно.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг 2018 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр Булган аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

1.3. Аудитын арга зүй

Булган аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй баталгаа олж авахын тулд санхүүгийн тайланг бэлтгэхэд баримталсан бодлого, зарчмуудыг үндэслэж, байгууллагын дансыг хамруулан түүвэрчилсэн байдалаар аудитын хяналтын ба нарийвчилсан горимыг хэрэгжүүлэв.

Аймгийн Төвсийн ерөнхийлөн захирагчийн 2017 оын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитыг 2018 оны 04 дүгээр сарын 01-нээс 2018 оны 04 дүгээр сарын 20-ны хооронд хийхээр төлөвлөн Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Д.Анхбаяр, аудитын менежер Ж.Энхцоодол, СТА-ын багийн ахлах аудитор П.Содном, аудитор Д.Даариймаа, А.Сувдаа, гэрээт аудитор З.Ганбаатар нар гүйцэтгэв.

1.4. 2017 оны санхүүгийн тайланг нэгтгэхэд баримталсан бодлого, аргачлал:

Аймгийн ИТХ-аар батлуулсан төсвийн хуваарийн дагуу аймгийн Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан Төсвийн ерөнхийлөн захирагч болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг бэлтгэсэн байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.36-д "төсвийн ерөнхийлөн захирагч гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг" гэж заасны дагуу Булган аймгийн Засаг дарга төсвийн ерөнхийлөн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Булган аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд дүгнэлт өгөх үүднээс Төсвийн ерөнхийлөн захирагч болон СТСХэлтсийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим дансад түүвэрчилсэн байдлаар аудитын хяналтын болон нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд тайлангаа нэгтгүүлдэг сумын ТТЗ-ийн нэгтгэсэн тайлангууд, аймгийн ИТХ, ЗДТГ, ОНХС, ОНХО, авто замын сан, СХС, төсөл сангууд, "Булган Мээж," "Тэшиг ус", "Илчит хутаг", Газрын харилцаа барилга, хот байгууллалтын газар, Хүүхэд гэр бүл залуучуудын хөгжлийн хэлтэс зэрэг тусгай шилжүүлгийн байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлангуудад аудит хийх явцад бидний анхаарлыг татсан санхүү, аж ахуйн үйл ажиллагаа нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын

системийн талаарх алдаа, зөрчил, асуудлуудыг аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүгнэлтэд багтааж байгаа болно.

Хоёр: Санхүүгийн дотоод хяналт, аудит

Төсвийн тухай хуулийн 14.1.17-д заасны дагуу аймгийн Засаг дарга нь Төсвийн Ерөнхийлөн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Төсвийн ерөнхийлөн захирагч орон нутгийн төсвийг аймгийн ИТХ-аар батлуулан жилийн төсвийг сар, улиралаар хуваарилан аймаг, сумын төрийн сангаар дамжуулан төсвийн төвлөрүүлэн захирагчид болон төсвийн шууд захирагч нарт олгож аймаг, сумдын санхүү албаны нар дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Төсвийн тухай хуулийн 69.3 дахь *"Дотоод аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагааг хамаарна."* гэж заасны дагуу санхүүгийн хяналт, дотоод аудитын алба ажиллаж байна. Засгийн газрын 2016 оны 483 дүгээр тогтоол, аудитын хорооны даргын баталсан тус албаны 2017 оны төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж нийт 268.8 сая төгрөгийн зөрчилд улсын байцаагчийн 111 акт тогтоож, 111.9 сая төгрөгийн зөрчлийг цаашид дахин давтан гаргахгүй байх талаар зөвлөж зөрчлийг арилгуулах 23 албан шаардлага өгч ажиллажээ.

Нийт тогтоогдсон төлбөрөөс 54.1 сая төгрөгийн төлбөрийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх, 208.8 сая төгрөгийн төлбөрийг тухайн байгууллагад төвлөрүүлэх, 5.5 сая төгрөгийн төлбөрийг хуулийн байгууллагад шилжүүлсэн. Үүнээс 27.7 сая төгрөгийг аймгийн төсвийн орлогод, 185.2 сая төгрөгийг тухайн байгууллагад төвлөрч, актын биелэлт 83.0 хувьтай, албан шаардлагын биелэлт 100 хувьтай байна.

Шалгалтаар илэрсэн зөрчлүүдийг ангилж үзвэл татвар хураамж 0.02, төсвийн хөрөнгийг бусдад зээлдүүлж түр ашиглуулсан 9.7, зориулалт бусаар зарцуулсан 2.9, үндсэн баримтгүй зарцуулсан болон данс бүртгэлд тусгаагүй 154.3, өр авлага үндэслэлгүй хаасан 5.1, цалин хөлс, томилолт илүү дутуу олгосон 64.8, ашигласан 10.0 сая төгрөгний зөрчил илэрсэн байна. Цаашид дотоод аудитын алба орон нутгийн төсвийн төлөвлөлт, орлого бүрдүүлэлт, төсөл сангийн үйл ажиллагаа, зэрэгт дотоод аудит хийх шаардлагатай байна.

Гурав: Шилэн данс мэдээлэл:

Булган аймгийн хэмжээнд Шилэн дансны хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасан төрийн өмчит 34 хуулийн этгээд, орон нутгийн өмчит 140 хуулийн этгээд, орон нутгийн өмчит үйлдвэрийн газар 16, нийт 190 байгууллага хамрагдахаас төсвийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд 100 хувь бүрэн хамрагдаж байна.

Шилэн дансны хуулийн 3.1.2-д заасан ТӨҮГ, ТӨХК-иуд Булган аймгийн хэмжээнд 7 салбар байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд Зам тээврийн хөгжлийн яамны харьяа Нисэх буудал, Булган АЗЗА, Автотээвэрийн үндэсний төв, 3 салбар шилэн дансны цахим хуудастай, бусад салбар болох Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Монголын цахилгаан холбоо ТӨХК, Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК, Монгол шуудан ТӨХК зэрэг байгууллагууд харьяалах дээд

шатны байгууллагад мэдээллээ нэгтгэн шилэн дансны цахим хуудсанд мэдээлдэг боловч орон нутагт салбартай ТӨҮГ, ТӨХК-ууд шилэн дансны цахим хуудсанд салбар байгууллага тус бүрээр эсвэл нэгтгэж мэдээлэх талаар Шилэн дансны тухай хуулинд тодорхой заагаагүй байна.

Булган аймгийн хэмжээнд Шилэн дансны тухай хуулийн 3.1.3-т заасан “Хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг эзэмшиж байгаа аж ахуй нэгж байгууллага” байхгүй болно.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-т заасан байгууллагууд бүрэн хамрагдаж, 3.1.4-д заасан аж ахуй нэгж, байгууллага бүрэн хамрагдахгүй байна. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газар хуулийн 6.1-д заасны дагуу тогтсон хугацаанд байршуулах мэдээллийг 96.8, 6.4 дэх хэсэгт заасан мэдээллийг 92.9 хувьтай мэдээлсэн.

Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-д заасан хөрөнгө оруулалт, ажил үйлчилгээ хэрэгжүүлсэн аж ахуй нэгж байгууллага тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.9-д заасан мэдээллийг журмын дагуу байршуулаагүй.

Хуулийн 5.7-д заасны дагуу мэдээллийн самбарт байрлуулж байгаа мэдээлэл нь дутуу, мэдээний чанар, стандартыг хангахгүй, зарим мэдээллийг огт мэдээллэхгүй байна.

Шилэн дансны үйл ажиллагаанд тавих хяналтыг аймгийн ИТХ, аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын алба тус тус хэрэгжүүлсэн ч, сумын ИТХ, багийн иргэдийн нийтийн хурлаас тавих хяналт хангалтгүй байна гэж дүгнэлээ.

Дөрөв: Материаллаг байдлыг тодорхойлох:

Булган аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2017 санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын дүнг 90258.9 сая төгрөг бөгөөд түүний 1 хувиар тооцон 902.6 сая төгрөгөөр материаллаг байдлын түвшинг тодорхойлж, баталгаажууллаа.

Тав. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар:

5.1 Мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагнал:

5.1.1 Мөнгөн хөрөнгийн бүтэцийн талаар:

Булган аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөнд дараах зүйлсийг бүртгэж тайлагнасан байна. Үүнд

- Төрийн сангийн харилцахын үлдэгдэл, байгууллага, арилжааны банкуудад байршдаг зарим төсвийн байгууллагын жижиг мөнгөн сан, харилцах дансдын үлдэгдэл, ОНӨҮГ-ууд, төсөл сөнгийн төгрөгийн харилцах дансдын үлдэгдэл
- Кассанд байгаа бэлэн мөнгө

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 2016 оны эцэст 5803.2 сая төгрөг байснаас 2017 оны жилийн эцэст 6860.9 сая төгрөгөөр тайлагнагдсан бөгөөд үүний 88.7 хувь буюу 5869.2 сая төгрөг нь төрийн сангийн харилцах дансанд байршиж байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн 2017 оны үлдэгдлийг бүтэц, байгууллагын төрлөөр харуулбал:

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Кассад байгаа бэлэн мөнгө	Банкинд байгаа бэлэн мөнгө	
				Арилжааны банк	Төрийн сангийн харилцах
Кассад байгаа бэлэн мөнгө	9.2	1.1	1.1		
Банкинд байгаа бэлэн мөнгө	5794.0	6859.7			
Төрийн сангийн харилцах	5263.0	5863.2			5863.2
Арилжааны банк	530.9	996.5		996.5	
Замд яваа мөнгө	-				
Нийт мөнгөн хөрөнгийн дүн	5803.3	6860.9	1.1	996.5	5863.2

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг байгууллагын төрлөөр нь харуулбал:

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Кассад байгаа бэлэн мөнгө	Арилжааны банк	Төрийн сангийн харилцах
ОН-ийн байгууллага	1003.78	760.7	-	246.9	513.85
ОН-ийн ерөнхий орлого	3439.41	4,158.82	0	0.01	4158.81
Сумын орлогын үлдэгдэл	247.46	225.38	0	0.01	225.37
Аймгийн ерөнхий орлого: үүнээс	3191.95	3933.44	0	0	3933.44
Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллага	0.17	-	-	-	0
ОНӨҮГ	531.62	744.64	1.14	743.50	0
Сангууд	828.31	1196.55	-	0.03	1196.52
Төсөвтэй төсөл сангууд	-	-	-	-	-
Нийт мөнгөн хөрөнгийн дүн	5803.30	6860.9	1.14	990.43	5863.2

Аймгийн хэмжээнд мөнгөн хөрөнгийн 2017 оын эцсийн үлдэгдэл 6860.9 сая төгрөгийн 7.7 хувь буюу 513.8 төсөвт байгууллагын, 62.8 хувь буюу 4158.8 төрийн сангийн, 11.3 хувь буюу 744.6 орон нутгийн өмчит газрын, 18.2 хувь буюу 1196.5 сая төгрөг нь төсөл сангуудын мөнгөн хөрөнгө эзэлж байна.

Төсөвт байгууллагын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 760.7 сая төгрөгөөс аймгийн 80-н жилийн хандив 246.9 сая төгрөгийг тайланд тусгасан байна. Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 5863.2 сая төгрөгийн 97.2 сая төгрөг нь сумдын давсан

орлого, 2262.5 сая төгрөг нь аймгийн давсан орлого болон төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл байна.

Төрийн санд байршиж буй харилцах дансдын үлдэгдлийг сумдаар нь харуулбал:

/сая.төг/

№	Сумын нэр	Өмнөх он	Тайлант он
1	Булган аймаг	3738.2	4414.9
2	Баян-Агт	71.9	47.5
3	Баяннуур	22.5	23.6
4	Бугат	55	90.6
5	Булган	219.8	163.3
6	Бүрэгхангай	45.9	133.5
7	Гурванбулаг	112.7	162.3
8	Дашинчилэн	106.8	152.8
9	Могод	39.6	55.2
10	Орхон	48.5	77.3
11	Рашаант	66.3	60.9
12	Сайхан	107.1	90.4
13	Сэлэнгэ	478.2	165.5
14	Тэшиг	17.1	32.3
15	Хангал	38.9	57.5
16	Хишиг-Өндөр	66.5	93.4
17	Хялганат	1.6	11.2
18	Хутаг-Өндөр	26.5	30.9
	Нийт	5263.1	5863.2

Аймгийн төрийн сан дахь мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 4414.9 сая төгрөгийн үлдэгдэлийн Булган хөгжил сан 4.3, авто замын сан 88.9, цэргийн гүйцүүлэх алба 12.3, мал хамгаалах сан 135.7, гамшигаас хамгаалах сан 80.9, орон нутгийн хөгжлийн сан 146.3 сая төгрөг тус тус байна.

Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 744.6 сая төгрөгийн 88.95 хувь буюу 662.3 сая төгрөг нь “Булган мээж” ХХК-ий үлдэгдэл байна.

Орон нутгийн төсвийн байгууллагуудын дүнгээр санхүүгийн тайланд хийсэн аудитаар мөнгөн хөрөнгийн зарцуулалт, санхүүгийн сахилга хариуцлагатай холбоотой дор дурдсан нийтлэг зөрчил байна.

Арван жилийн нэгдүгээр сургууль хичээл үйлдвэрлэлийн зардлаас 7860.8 мянган төгрөгийн буцалтгүй тусламж, шагнал, бэлэг авахад зарцуулсан,

Орхон сумын сургууль дотуур байранд оршин суугчаас сарын 50.0 мянган төгрөгийн түрээс төлөхөөр гэрээ хийсэн тайлант онд түүрээсийн 2337.0 мянган төгрөг бэлнээр орсон боловч нэмэлт санхүүжилтын дансаар дамжуулж санхүүгийн тайланд тусгаагүй, эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр зарцуулсан.

Орхон сумын сургууль нормын хувцас зөөлөн эдлэлийн зардлаас 571.8 мянган төгрөгөөр хоол хүнсний материал худалдан авч Сангийн сайдын 2013 оны 73

дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу зардлыг бүлэг хооронд зохицуулалт хийлгүүгээр зарцуулсан,

Өмнөх онд аймгийн ЗДТГ 65.0 сая төгрөгөөр орон сууц худалдан авч 28.0 сая төгрөгийн төлжээ. Жилийн эцсийн санхүүгийн тайланд 37.0 сая төгрөгийг өглөг үүсгээгүй үнэ төлбөргүй үндсэн хөрөнгө дансанд бүртгэсэн. 2017 онд үлдэгдэл 37.0 сая төгрөгийг төлж тайланд бараа үйлчилгээний бусад зардалд шууд бичиж тайлагнасан,

5.2.АВЛАГЫН БҮРТГЭЛ, ТАЙЛАГНАЛ:

5.2.1 Авлагын бүтэц, бүрэлдэхүүн талаар:

Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт авлагын эхний үлдэгдэл 5395.1 сая төгрөг байснаас тайлант онд 258.9 сая төгрөгөөр буурч оны эцэст 5136.2 сая төгрөгөөр тайлагнагдсан байна.

Нийт авлагын 0.2 хувь ажилчидтай холбоотой авлага, 82.9 хувь нь хувь хүнээс авах авлага, 0.19 хувь нь төлбөртэй үйлчилгээний авлага, 14.2 хувь байгууллагаас авах авлага, 0.09 хувь нь зээлийн хүүгийн авлага, 0.02 хувь нь татвар НДШ-ийн авлага, 2.28 хувь нь засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон авлага тус тус эзэлж байна.

Авлагын бүтцийг авч үзвэл байгууллагаас авах авлага 40.0, хувь хүнээс авах авлага 163.2, Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон авлага 66.3 сая төгрөгөөр буурсан, харин ажилчидтай холбоотой авлага 5.0 сая төгрөгөөр өссөн байна.

Нийт авлагын үлдэгдлийг бүтэц, байгууллагаар нь харуулбал (сая. төг)

Авлагын ангилал	Эхний үлдэгдэл	Эцийн үлдэгдэл	Зөрүү	Хувиар
Ажилчидтай холбоотой авлага	6.4	11.4	5.0	0.22%
Төлбөртэй үйлчилгээний авлага	6.6	9.6	3.0	0.19%
Зээлийн хүүгийн авлага	2.2	4.8	2.6	0.09%
Дансны авлага /ТӨҮГ/	0.2	0.2	0	0.00%
Татвар НДШ-ын авлага /ТӨҮГ/	1.1	1.1	0.0	0.02%
Байгууллагаас авах авлага	769.8	729.8	-40.0	14.2%
Хувь хүнээс авах авлага	4425.5	4262.4	-163.2	82.9%
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон	183.2	116.9	-66.3	2.28%
Нийт дүн	5395.1	5136.2	-258.9	100.0%

Үүнээс байгууллагын төрлөөр харуулбал:

Байгууллага нэрс	Эхний үлдэгдэл	Эцийн үлдэгдэл	Зөрүү	Хувиар
Төсвийн байгууллага	112.6	99.6	(13)	2%
Төрийн сан	214.2	148	(66.2)	3%
Төсөл сан	4840.4	4712.8	(127.6)	92%
ОНӨҮГазар	227.9	175.8	(52.1)	3%

БУЛГАН АЙМГИЙН ТЕЗ-ИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Нийт дүн	5395.1	5136.2	(258.9)	100%
----------	--------	--------	---------	------

Булган аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хувь хүнээс авах дансанд бүртгэлтэй зээлийн авлагыг 2017 онд зээлийн авлага дансанд шилжүүлэн нэгтгэсэн байна.

Авлагын дансны үлдэгдлийг байгууллагын төрлөөр авч үзвэл нийт авлагын 2 хувь нь төсөвт байгууллагын, 3 хувь нь төрийн сангийн, 3 хувь нь ОНӨҮГ-ын, 92 хувь нь төсөл сангийн авлага буюу сум хөгжүүлэх сан, жижиг дунд үйлдвэрийн сан, баг хөгжүүлэх сан болон бусад эргэн төлөгдөх нөхцөлтэй олгодог зээлүүдтэй холбоотой төсөл сангийн авлага байна. Тайлант онд төсвийн байгууллага, төрийн сан, төсөл сан, орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын нийт авлага 258.9 сая төгрөгөөр буурсан байна.

Нийт авлагыг сум тус бүрээр хүснэгтээр харуулбал:

(сая. төг)

Сумын нэр	Эхний үлдэгдэл	Эцийн үлдэгдэл	Зөрүү	Хувиар
Баян-Агт	244.3	291.0	46.7	6%
Баяннуур	227.7	240.0	12.4	5%
Бугат	262.7	230.6	-32.1	4%
Булган	934.2	990.9	56.7	19%
Булган аймаг	754.8	626.3	-128.5	12%
Бүрэгхангай	204.3	173.0	-31.4	3%
Гурванбулаг	184.4	152.8	-31.6	3%
Дашинчилэн	191.8	131.6	-60.2	3%
Могод	192.2	182.4	-9.8	4%
Орхон	337.7	334.5	-3.2	7%
Рашаант	252.7	252.1	-0.6	5%
Сайхан	297.1	276.4	-20.7	5%
Сэлэнгэ	155.4	143.7	-11.7	3%
Тэшиг	308.4	283.3	-25.1	6%
Хангал	275.3	270.3	-5.0	5%
Хялганат	36.6	30.4	-6.2	1%
Хишиг-Өндөр	221.8	216.9	-4.9	4%
Хутаг-Өндар	313.8	310.0	-3.8	6%
Нийт	5395.1	5136.2	-258.9	100%

Авлагыг сумдаар авч үзвэл Булган аймаг 128.5, Дашинчилэн сум 60.2, Бугат сум 32.1, Гурванбулаг 31.6 сая төгрөгөөр авлагыг бууруулсан, Баян-Агт сум 46.7, Баяннуур сум 12.4, Булган сум 56.7 сая төгрөгөөр авлагыг нэмэгдүүлсэн байна.

Төсвийн шууд захирагчид авлагатай ажиллаж байгаа нь “Төсвийн тухай хуулийн 6.4.8 “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Аудитаас төсөв захирагч бүрд авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авах, Төсвийн тухай хуулийг мөрдөж ажиллах зөвлөмжийг хүргүүлж ажиллалаа.

Тухайлбал: Булган сумын тохижилт үйлчилгээний анги тайлант оны эхэнд 2301.6 мянган төгрөгийн авлагатай байснаас авлагын эхний үлдэгдэл барагдаж, тайлант онд 477.9 мянган төгрөгийг үйлдвэрчний эвлэлд илүү шилжүүлснийг авлагаар бүртгээгүйг аудитын явцад залрууллаа.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 20.1.4-д заасан заалтуудын дагуу авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, анхан шатны баримтыг үндэслэн тайланд үнэн, зөв тусгаж байх шаардлагатай байна.

5.2.2.Төсөл сангийн авлагыг тодруулбал:

Төсөл сангийн авлага нь төсөл сангийн шугамаар иргэдэд олгож байгаа зээлийн эргэн төлөлт мөн эргэн төлөгдөх нөхцлөөр жижиг дунд үйлдвэрлэл дэмжих зорилгоор СХС-гаас олгосон зээлтэй холбоотой үүссэн бөгөөд авлагын эхний үлдэгдэл 4175.1 сая төгрөг байснаас өмнөх оноос 104.6 сая төгрөгөөр буурсан нь 2017 онд зээлийн эргэн төлөлт хангалтгүйгээс Бугат, Гурванбулаг, Орхон, Тэшиг сумдууд огт зээл олгоогүй бусад сумдууд 165 иргэнд 694.3 сая төгрөгийн зээл олгож авлагын эцсийн үлдэгдэл үлдэгдэл 4070.7 сая төгрөг байна. Үүний 1766.5 сая төгрөгийн 546 иргэнтэй холбоотой сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт хугацаа хэтрэлттэй байна.

Сум хөгжүүлэх сангийн авлагыг сумдаар харуулбал:

/ сая.төг/

Сум нэр	эхний	эцсийн	Хугацаа хэтэрсэн зээл	
	үлдэгдэл	үлдэгдэл		
	Дүн /сая.төг/	Дүн /сая.төг/	тоо	дүн /сая.төг/
Баян-Агт	174.7	215.4	23	41.7
Баяннуур	196.4	185.0	51	185.0
Бугат	213.6	213.6	52	82.0
Булган	925.2	972.2	63	340.6
Бүрэгхангай	183.0	137.1	21	85.3
Гурванбулаг	184.4	152.8	17	93.3
Дашинчилэн	187.4	131.6	40	37.0
Могод	185.0	170.6	12	60.5
Орхон	321.7	317.4	41	143.8
Рашаант	232.7	235.3	16	59.9
Сайхан	247.6	271.3	43	105.2
Сэлэнгэ	158.1	142.5	48	117.3
Тэшиг	248.0	236.5	48	160.9
Хангал	262.7	255.0	16	77.2
Хишиг-Өндөр	205.1	200.6	12	57.0

БУЛГАН АЙМГИЙН ТЕЗ-ИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Хутаг-Өндөр	249.7	234.0	43	119.9
Нийт	4175.1	4070.75	546	1,766.47

ОНТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн төсөл сангийн авлагын судалгаанаас үзэхэд холбогдох албан тушаалтнууд авлагын тооцоог тухай бүр хийж барагдуулах талаар тодорхой арга хэмжээ аваагүй, санал санаачлага гаргахгүй байгаагаас авлага он дамжин хадгалагдаж, насжилт нэмэгдэн улмаар төлөгдөх найдваргүй болох нөхцөл байдал үүсч болзошгүй болсон байна. Бүх сумдад СХС-ийн зээлийн эргэн төлөлтөнд анхаарч, тодорхой арга хэмжээг цаг алдалгүй авах, МУ-ын Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолын 6.2. "... төслийн хэрэгжилтэд зохих журмын дагуу хяналт тавьж ажиллаагүй болох нь эрх бүхий этгээдийн хяналт шалгалтаар тогтоогдсон бол тухайн сумын Засаг дарга болон холбогдох бусад албан тушаалтанд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ." гэсэн заалтын дагуу хугацаа хэтрэлттэй сумдын Засаг дарга нарт хариуцлага тооцох санал хүргүүлж байна.

5.2.3.Төрийн сангийн авлагыг тодруулбал:

Төрийн сангийн авлага нийт 147.9 сая төгрөг байгаагаас 2001 онд үүссэн 16 жилийн насжилттай өвс тэжээлийн авлага 1.1, "Атрын III" аяны хүрээнд иргэдэд эргэн төлөгдөх нөхцлөөр олгосон зээлийн авлага 116.9 сая төгрөг, эдгээр авлагыг барагдуулах талаар өмнөх жилүүдийн аудитаар зөвлөмж хүргүүлж байсан ч зөвлөмжийн мөрөөр тодорхой үр дүнтэй арга хэмжээ аваагүй атрын 3-р аяны зээлээс 66.2 сая төгрөгийг барагдуулсанаас өөр өөрчлөлт ороогүй байна.

5.2.4.ОНӨҮГ-ын авлагыг тодруулбал:

ОНӨҮГ-ын авлага өмнөх онд 227.9 сая төгрөг байсан бол энэ онд 175.8 сая төгрөг болж 52.2 сая төгрөгөөр буурсан байна.

5.3.БАРАА МАТЕРИАЛЫН БҮРТГЭЛ, ТАЙЛАГНАЛ:

5.3.1.БАРАА МАТЕРИАЛЫН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТАЛААР:

ОНТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт бараа материалын үлдэгдэл 5963.2 сая төгрөг болж 1193.2 сая төгрөгөөр өссөн байна.

Материалын төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт, бууралт
Тусгай зориулалтын материал	404.2	615.5	211.6
Эм боох материал	241.9	230.6	(11.3)
Бэлэн бүтээгдэхүүн	13.7	15.4	1.7
Бичиг хэргийн материал	94.1	107.8	13.8
Аж ахуйн материал	1915.9	2128.2	212.3
Сэлбэг хэрэгсэл	103.8	133.7	29.8
Түлш, шатах тослох материал	196.3	212.9	16.6
Барилгын засварын материал	48.3	70.1	21.8
Хүнсний материал	382.4	300.8	(81.6)
Бусад хангамжийн материал	903.8	1,657.3	753.5
Мал амьтад	465.6	427.5	(38.1)

Нөөцийн бараа		62.9	62.9
ДҮН	4769.9	5,963.2	

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 7298.7 сая төгрөгийн бараа материал худалдан авсан бөгөөд хандив тусламжаар 235.3, шилжүүлгээр болон бүтцийн өөрчлөлтөөр 604.4, бусад эх үүсвэрээс 396.9 сая төгрөгийн бараа материалыг авч, тайлант онд 6866.2 сая төгрөгийн хөрөнгийг зарцуулж, шилжүүлгээр болон бүтцийн өөрчлөлтөөр 88.2, бусад болон актлаж устгасан 387.6 сая төгрөгийн хөрөнгө хасагдаж хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 1193.2 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Тусгай зориулалтын материал өмнөх оноос 211.6 сая төгрөгөөр, бэлэн бүтээгдэхүүн 1.7, бичиг хэргийн материал 13.8, аж аухйн материал 212.3, барилгын материал 21.8, хангамжийн материал 753.5, түлш шатах тослох материал 16.6 сая төгрөгөөр тус тус өссөн, харин эм боох материал өмнөх оноос 11.3, хүнсний материал 81.5 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

Байгууллагын төрлөөр харуулбал:

Байгууллагаар	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү
ОН-ийн байгууллага	1,146.8	2,075.2	928.3
Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллага	2,969.4	3,349.8	380.4
ОНӨҮГ	653.8	538.2	(115.5)
Нийт дүн	4,769.9	5,963.2	1,193.2

Мал амьтад нь төсвийн байгууллагын бараа материалын бүрэлдэхүүнд орж байгаа бөгөөд өмнөх оноос 38.1 сая төгрөгөөр буурчээ.

Нийт бараа материалын үлдэгдлийн 34.8 хувь буюу 2075.2 сая төгрөг нь орон нутгийн төсөвт байгууллагын, 56.2 хувь буюу 3349.8 сая төгрөг нь тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллага, 9 хувь 538.2 сая төгрөг нь ОНӨҮГ газрын бараа материал тус тус эзэлж байна.

Бараа материалын данс бүртгэлтэй холбоотой Төсвийн шууд захирагчдын жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн асуудлын талаар:

- Орхон сумын эрүүл мэндийн төв: Бараа материалын тайланд 14549.5 мянган төгрөгийн эм худалдан авч, 13911.3 мянган төгрөгийн эм зарлагдсан ч санхүүгийн тайлангийн программын бүртгэлд 8, 9, 10, 11 дүгээр сард эмийн зардал бүртгээгүй 12 дугаар сард 6830.9 мянган төгрөгийн эмийг нэр төрлөөр бус нийт дүнгээр тайланд зарлагдсан, няравийн тайлангийн орлого зарлагаас зөрүүтэй бүртгэдэг, дууссан эмээс зарлагдаж хасах дүнтэй үлдэгдэлтэй эмийн тайлан гаргасан байна.
- Орхон сумын цэцэрлэг : 2017 оны жилийн эцсийн бараа материалын тодруулга тайлангаар эм 33.6, бичиг хэргийн 198.4, аж ахуйн материалын 346.0, түлш шатах тослох материалын 3717.2, хүнсний 4123.6, бусад

хангамжийн материалын 15158.3 нийт 23977.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гэж тайлагнасан боловч бараа материалын тооллого хийгээгүй нь НББ-ийн тухай хуулийн 12.2 дахь “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ:”, “12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө;” гэж заасныг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй байна

- Булган сум тохижилт үйлчилгээний анги: Бараа материалын тайлан, санхүүгийн тайлангийн тусгай зориулалт материалын орлого 2959.6, зарлага 1717.2, бичиг хэргийн орлого 395.4, зарлага 256.0, аж ахуйн материалын орлого 2630.7, зарлага 6599.2, сэлбэг хэрэгслийн орлого 11397.4, зарлага 5886.2, гэрэл цахилгааны материалын орлого 2340.0 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан.

5.4.ҮНДСЭН ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛ, ТАЙЛАГНАЛ:

5.4.1.ҮНДСЭН ХӨРӨНГИЙН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТАЛААР:

ОНТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгдсэн тайланд үндсэн хөрөнгө 152255.9 сая төгрөгөөр тайлагнагдсан бөгөөд өмнөх оноос 10.9 хувиар буюу 14984.8 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Үндсэн хөрөнгийг нэр төрлөөр нь харуулбал:

Ангилал	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт+ Бууралт- /сая.төг/	
			тоогоор	Хувиар
Барилга байгууламж	99,476	107,543	8,067	8.11%
Тээврийн хэрэгсэл	5,820	6,097	277	4.76%
Машин тоног төхөөрөмж	9,729	11,294	1,565	16.09%
Тавилга эд хогшил	4,815	5,165	350	7.27%
Зам гүүрний байгууламж	2,876	2,902	26	0.90%
Батлан хамгаалахын тоног төхөөрөмж	0	0		0.00%
Түүх соёлын дурсгалт зүйл	1,029	1,029	0	0.01%
Дуусаагүй барилга байгууламж	6,871	9,792	2,921	42.51%
Номын фонд	694	735	42	6.03%
Бусад үндсэн хөрөнгө	5,801	7,530	1,729	29.81%
Програм хангамж	126	134	8	6.22%
Бусад биет бус хөрөнгө	4	4		0.00%
Бусад хөрөнгө				
Нийт дүн	137,240	152,225	14,985	10.92%


Байгууллагын төрлөөр харуулбал

Үзүүлэлт	Энхий үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт+ Бууралт- Тоогоор	
			Тоогоор	Хувиар
Төсөвт байгууллага	71,992	83,451	11,458	15.92%
Төсөл/Сан	0	0	0	0.00%
Төрийн сан	0	0	0	0.00%
ТӨҮГ болон ОНӨҮГ	4,847	5,120	272	5.61%
Нэгтгэсэн нийт дүн	76,840	88,570	11,730	15.27%

Нийт үндсэн хөрөнгийн 99.9 хувийг биет хөрөнгө үлдэх 0.1 хувийг биет бус хөрөнгө эзэлж байна. Өмнөх оноос барилга байгууламж 8.1 хувь буюу 8067.1, тээврийн хэрэгсэл 4.7 хувь буюу 277.0, машин тоног төхөөрөмж 16.1 хувиар буюу 1564.9, тавилга эд хогшил 7.2 хувь буюу 350.2, зам гүүрний байгууламж 1 хувь буюу 26.0, дуусаагүй барилга байгууламж 42.5 хувь буюу 2920.1, номын фонд 6 хувь буюу 41.8, бусад үндсэн хөрөнгө 29.8 хувь буюу 1729,0 сая төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна. Тайлант хугацаанд үндсэн хөрөнгө 20791.7 сая төгрөгөөр нэмэгдсэн ба үүний дотор төсвийн хөрөнгөөр 1284.0, хандиваар 1115., шилжүүлж авсан 12038.3, бүтцийн өөрчлөлтөөр 429.9 сая төгрөг, бусад 5921.8 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Харин үндсэн хөрөнгө 5806.9 сая төгрөгөөр хасагдсаны дотор худалдсан 21.1, акталсан 885.2, шилжүүлсэн 4064.8 бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн 816.3, бусад 19.8 сая төгрөг тус тус байна.

Нийт үндсэн хөрөнгөд эзлэх хувь



Нийт үндсэн хөрөнгийн 71 хувийг барилга байгууламж, 4 хувийг үндсэн хөрөнгө, 7 хувийг машин тоног төхөөрөмж, 3 хувийг тавилга эд хогшил, 2 хувийг зам гүүрний байгууламж, 1 хувийг түүх соёлын дурсгалт зүйлс, 6 хувийг дуусаагүй барилга, 5 хувийг бусад үндсэн хөрөнгө тус тус эзэлж байна.

5.4.2.ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ:

ОНТЕЗ-н санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл 2016 оны эцэст 60400.4 сая төгрөг байснаас тайлант хугацаанд 58484.2 сая төгрөгийн элэгдэл байгуулагдан, өмнөх оны элэгдэлийн зөрүү 169.5 сая төгрөгөөр хасагдаж 2763.0 сая төгрөгийг данснаас хасч тайлант онд 63655.1 сая төгрөгөөр тайлагнагдсан байна. Үүнээс:

- ❖ Барилга байгууламжийн хуримтлагдсан элэгдэл 2016 оны эцэст 47401.1 сая төгрөг байснаас тайлант онд 2585.3 сая төгрөгийн элэгдэл байгуулагдаж, 1774.3 сая төгрөгийг данснаас хасч 48,363.1 сая төгрөгөөр
- ❖ Тээврийн хэрэгслийн хуримтлагдсан элэгдэл 2016 оны эцэст 2816.3 сая төгрөг байснаас тайлант онд 916.6 сая төгрөгийн элэгдэл байгуулагдаж, 360.3 сая төгрөгийг данснаас хасч 3373.0 төгрөгөөр
- ❖ Машин тоног төхөөрөмжийн хуримтлагдсан элэгдэл 2016 оны эцэст 4577.0 сая төгрөг байснаас тайлант онд 1157.3 сая төгрөгийн элэгдэл байгуулагдаж, 320.4 төгрөгийг данснаас хасч 5419.3 сая төгрөгөөр
- ❖ Тавилга эд хогшлын хуримтлагдсан элэгдэл 2016 оны эцэст 2666.8 сая төгрөг байснаас тайлант онд 440.3 сая төгрөгийн элэгдэл байгуулагдаж, 208.1 сая төгрөгийг данснаас хасч 2904.0 сая төгрөгөөр
- ❖ Зам гүүрний байгууламжийн хуримтлагдсан элэгдэл 2016 оны эцэст 539.8 сая төгрөг байснаас тайлант онд 81.7 сая төгрөгийн элэгдэл байгуулагдаж 621.5 сая төгрөгөөр
- ❖ Батлан хамгаалхын тоног төхөөрөмжийн хуримтлагдсан элэгдэл 2016 оны эцэст 0.4 сая төгрөг байснаас 0.04 сая төгрөгийн элэгдэл байгуулагдаж, 0.2 сая төгрөгөөр
- ❖ Бусад үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл 2016 оны эцэст 2,306.1 сая төгрөг байснаас тайлант онд 661.6 сая төгрөгөөр элэгдэл байгуулагдаж, 95.8 сая төгрөгийг данснаас хасч 2,872.0 сая төгрөгөөр
- ❖ Програм хангамжийн хуримтлагдсан элэгдэл 2016 оны эцэст 92.0 сая төгрөг байснаас тайлант онд 9.0 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэл байгуулагдаж, 0.3 сая төгрөгийг данснаас хасч 101.0 сая төгрөгөөр
- ❖ Биет бус хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл 2016 оны эцэст 1.3 сая төгрөг байснаас 0.4 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэл байгуулагдаж 1.6 сая төгрөгөөр тус тус тайлагнагдсан байна.

5.4.3. ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ АВСАН БОЛОН АКТАЛСАН ҮНДСЭН ХӨРӨНГӨ:

Тайлант хугацаанд 1116.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр болон хандиваар авч бүртгэл тайланд тусгасны 29.7 хувь буюу 331.7 сая төгрөг нь барилга байгууламж, 17.2 хувь буюу 192.4 сая төгрөг нь тээврийн хэрэгсэл, 26.7 хувь буюу 300.8 сая төгрөг нь машин тоног төхөөрөмж, 9.7 хувь буюу 108.0 сая төгрөг нь тавилга эд хогшил, 14.4 хувь буюу 161.4 сая төгрөг нь бусад үндсэн хөрөнгө, үлдэх 1.9 хувь буюу 21.1 сая төгрөг нь зам гүүрний байгууламж, түүх соёлын дурсгалт зүйлс, номын фонд эзлэж байна.

Мөн тайлант хугацаанд 885.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчидийн тогтоол болон Орон нутгийн өмчийн газрын зөвшөөрлөөр акталсан байна.

Үндсэн хөрөнгийн данс бүртгэлтэй холбоотой Төсвийн шууд захирагчдын жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн асуудлын талаар:

- /Орхон сумын эрүүл мэндийн төв, Баяннуур сумын суурь боловсролын сургууль : Үндсэн хөрөнгийн тооллого хийхдээ хөрөнгийн нэр төрөл тус

- бүрээр хийж, эд хөрөнгө эзэмшигчийн бүртгэл хөтлөөгүй нь Төрийн өмчийн болон орон нутгийн тухай хуулийн 70.2 болон 70.3 дахь заалтуудыг зөрчсөн.
- /Баяннуур сумын суурь боловсролын сургууль/: Тайлант хугацаанд хандиваар ирсэн хөрөнгийг 560.0 мянган төгрөгөөр, бусад үндсэн хөрөнгийн элэгдлийг 572.3 мянган төгрөгөөр тус тус илүү, тоног төхөөрөмжийг 980.0 төгрөг, элэгдэлтэй хасагдсан хөрөнгийг 26223.5 мянган төгрөгөөр тус тус дутуу нийт 27215.8 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын хугацаанд залрууллаа.
 - /Булган сумын ЗДТГ/: Санхүүгийн тайлан балансад барилга байгууламжийн 2691.5 сая төгрөг, Тоног төхөөрөмжийн 735.6 сая төгрөгийн, Тавилга эд хогшилын 180.1 нийт 3607.3 сая төгрөгийн элдэгдэл тооцогдсон ч балансад тусгаагүйг НББ-ийн тухай хуулийн 15.1.Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна. гэсэн заалтыг үндэслэн аудитын явцад залрууллаа.
 - Бараа материалын тайлан, бичиг хэргийн дансанд үндсэн хөрөнгийн шинж чанартай 1.4 сая төгрөгийн хөрөнгө бүртгэсэн, байгууллагын өмч хамгаалалын зөвлөлөөр оруулан шийдвэрлүүлэх, хөрөнгийн тооллого тооцоог чанартай хийж ашиглалтын шаардлага хангахгүй бараа материалыг данс бүртгэлээс хасах./Булган сумын ЗДТГ/
 - /Булган сумын тохжилт үйлчилгээний анги/: Жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор соёл амралтын цэцэрлэгт хүрээлэнгийн хөрөнгө болох барилга 1755.8, тоног төхөөрөмж 916.1, тавилга эд хогшил 12.8 нийт 2684.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн тооллого хийгээгүй.
 - /Баяннуур сумын цэцэрлэг/: Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд номын зардлын актлах хөрөнгө 990.6, бусад үндсэн хөрөнгийн элэгдэл 504.6 элэгдлийн зардал 1,495.2 мянган төгрөгийн тайлант оны элэгдэлийн зардлыг тайлагнаагүй нь "Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагад мөрдөх НББ-ийн дансны заавар, санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлал"-ыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.
 - /Орхон сумын цэцэрлэг/: Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд барилга байгууламж 26,773.1, тоног төхөөрөмж 161,31.4, эд хогшил 7,976.0, бусад үндсэн хөрөнгө 11.1 сая нийт 61,934.4 сая төгрөгийн элэгдлийг илүү байгуулж тайлагнасан нь "Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагад мөрдөх НББ-ийн дансны заавар, санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлал"-ыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

5.5.ӨР ТӨЛБӨРИЙН БҮРТГЭЛ, ТАЙЛАГНАЛ:

5.5.1.ӨР ТӨЛБӨРИЙН БҮТЦИЙН ТАЛААР:

ОНТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 589.2 сая төгрөг байснаас тайлангийн эцэст 556.8 сая төгрөг болж 32.4 сая төгрөгөөр буурсан байна.

БУЛГАН АЙМГИЙН ТЕЗ-ИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Нийт өр төлбөрийн үлэгдлийг бүтэц, байгууллагын төрлөөр харуулбал:

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцийн үлдэгдэл	Зөрүү	Хувиар
Арилжааны банк	0	4.7	4.7	1%
Ажилчидтай холбогдсон өглөг	28.3	21.6	-6.7	4%
Бараа үйлчилгээний зардлын өглөг	131.3	103.7	-27.6	19%
Байгууллагад төлөх өглөг	346.1	317.1	-41.6	55%
Хувь хүмүүст төлөх өглөг	38.9	81.8	42.9	15%
Татварын өглөг	38.4	25.0	-13.1	5%
НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	6.2	2.9	2.9	2%
Нийт	589.2	556.8	32.4	

Нийт өр төлбөрийн 58 хувь нь төсөвт байгууллага, 41 хувь нь орон нутгийн үйлвэрийн газар, 1 хувь нь төрийн сангийн өр төлбөр эзэлж байна.

Өр төлбөрийг сумаар авч үзвэл :

Сумдын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	Хувиар
Баян-Агт	10.86	13.12	2.26	2%
Баяннуур	24.90	17.80	-7.10	2%
Бугат	19.89	18.47	-1.43	3%
Булган	7.20	2.47	-4.73	0%
Булган шууд	262.14	300.63	38.49	55%
Бүрэгхангай	2.13	2.13	0.00	0%
Гурванбулаг	9.71	3.66	-6.05	1%
Дашинчилэн	5.52	10.57	5.05	2%
Могод	8.37	6.08	-2.29	1%
Орхон	44.86	15.44	-29.42	3%
Рашаант	8.99	0	-8.99	0%
Сайхан	13.47	4.07	-9.40	1%
Сэлэнгэ	7.16	18.46	11.30	3%
Тэшиг	112.06	98.80	-13.26	18%
Хангал	0.41628	0	-0.42	0%
Хишиг-Өндөр	1.63	2.82	1.19	1%
Хутаг-Өндөр	39.33	42.18	2.85	8%
Хялганат	10.52	0	-10.52	0%
Нийт	589.2	556.8	-32.4	100%

Сум, тосгоны дүнгээр өглөг нийт 32.4 сая төгрөгөөр буурсан ч Баян-Агт сум 2.3, Булган аймаг 38.5, Сэлэнгэ сум 11.3, Хишиг-Өндөр сум 1.2, Хутаг-Өндөр сум 2.9 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Өр төлбөртэй холбоотой гарсан алдаа зөрчил:

Булган сумын тохижилт үйлчилгээний анги: Тайлант оны эхэнд 0.3 сая төгрөгийн өглөгтэй байснаас, оны эцэст 0.7 сая төгрөгийн өглөгтэй тайлагнасан байна. Тухайн өр төлбөр үүсгэх болсон шалтгааныг гэрээ, анхан шатны баримт, тооцоо нийлсэн актыг хөөн шалгахад анхан шатны баримт тооцоо нийлсэн актгүйгээр үүсгэсэн, ХХОАТ 0.3 сая төгрөгийн өглөг тайланд тусгаагүйг аудитын явцад залруулан төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 20.1.4-д заасан заалтуудын дагуу авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, анхан шатны баримтыг үндэслэн тайланд үнэн, зөв тусгаж байхыг зөвлөж ажиллалаа.

5.6.ОРЛОГО, ТАТААС, САНХҮҮЖИЛТ:

5.6.1.ТӨСВИЙН ОРЛОГО:

УИХ-аас баталж, сангийн яамнаас хуваарилан хянаснаар 2017 онд орон нутгийн орлогоор 17906.1 сая төгрөг оруулах төлөвлөгөө ирүүлснийг аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуралдааны 06/01 тоот тогтоолоор аймагт төвлөрөх татварын орлогыг 17069.2 сая төгрөгөөр, сумдын ИТХ-ын хуралдааны тогтоолоор суманд төвлөрөх орлогыг 1689.4 сая төгрөгөөр буюу аймгийн дүнгээр нийт 18785.6 сая төгрөгийн орлого оруулахаар төлөвлөн батлахдаа цалин хөлс 96.0, үйл ажиллагааны орлого 24.7, шууд бус орлого 246.7, хог хаягдлын үйлчилгээний хураамж 49.9, Улсын тэмдэгийн хураамж 54.0, ан амьтны нөөц ашигласны төлбөр 32.6, түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 30.8 сая тус тус нэмэгдүүлэн баталсан бол ойн нөөц ашигласны төлбөр 36.3 сая төгрөгөөр бууруулан баталсан байна.

2017 оны нийт орлого 2249.0 сая төгрөгөөр буюу 112.1 хувиар давж биелсэн нь төсвийн орлого өмнөх оноос 949.4 сая төгрөгөөр өссөн сайн талтай байна.

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг харуулбал

/ мян.төг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ОРЛОГО	18785664	21034668.1	2249004.2	112.0
ТАТВАРЫН ОРЛОГО	18237060	20509687.8	2272627.6	112.5
Орлогын албан татвар	4462633.9	4603396.7	140762.8	103.2
Хувь хүний орлогын албан татвар	4462633.9	4603397	140762.8	103.2
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	4188010.1	4138286.6	-49723.5	98.8
Хувь хүний орлогын буцаалт	-495189.8	-495189.7	0.1	100
Үйл ажиллагааны орлого	214011.9	128484.2	-85527.7	60.0
Хөрөнгийн орлого	9123.5	104543.1	95419.6	1145.9
Шууд бус орлого	546678.2	727126.5	180448.3	133.0
Хөрөнгийн албан татвар	700510	718080.5	17570.5	102.5
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	380000	385159.1	5159.1	101.4
Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	254620	272514.1	17894.099	107.0

БУЛГАН АЙМГИЙН ТЕЗ-ИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Бууны албан татвар	65890	60407.3	-5482.72	91.7
Бусад нийтлэг төлбөр, хураамж	532002	451398.3	-80603.693	84.8
Улсын тэмдэгтийн хураамж	189000	151728.3	-37271.716	80.3
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	65887.5	74229.9	8342.4	112.7
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	145114.5	89827.3	-55287.2	61.9
Ашигт малтмалаас бусад байгалийн нөөц ашигласны зөвшөөрөл олгох	130000	136607.5	6607.5	105.1
Бусад татвар	2000	0	-2000	0.0
Газрын төлбөр	321000	405092.1	84092.1	126.2
Газрын төлбөр	221000	305092.1	84092.1	138.1
Дуудлага худалдаа	100000	100000	0	100
Байгалийн нөөц ашигласны төлбөр	12220914	14331720.3	2110806.0	117.3
Ойн нөөц ашигласны төлбөр	331716.4	310734.0	-20982.4	93.7
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	26220	51402.8	25182.8	196.0
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	11859278	13966245.2	2106967.3	117.8
Нохойн татвар	2500	678.7	-1821.3	27.1
Байгалийн ургамал ашигласны төлбөр	1200	2084	884	173.667
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	528603.7	476205.3	-52398.4	90.1
Нийтлэг татварын бус орлого	528603.7	476205.3	-52398.4	90.1
Хувьцааны ногдол ашиг	13230	38415.5	25185.5	290.4
Торгуулийн орлого	402450	355596.1	-46853.9	88.4
Бусад орлого	7526	16732.7	9206.7	222.3
Түрээсийн орлого	19981.3	24574.4	4593.1	123.0
Хүүгийн орлого	0	16560.3	16560.3	#DIV/0!
Бусад орлого	85416.4	24326.3	-61090.1	28.5
Хөрөнгийн орлого	20000	48775	28775	243.9
Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	20000	48775	28775	243.9

Орон нутгийн орлогын 97.5 % буюу 20509.7 сая төгрөг татварын орлогоос, 2.3 % буюу 476.2 сая төгрөг татварын бус орлогоос, 0.2 % буюу 48.8 сая төгрөг хөрөнгийн орлогоос тус тус бүрджээ.

Орон нутгийн төсвийн орлогын тайлангаас үзэхэд батлагдсан орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ 2249.0 сая төгрөгөөр давж биелэгдсэн хэдий ч орлогын нэр төрлөөр үзвэл жигд ханган биелүүлээгүй байна. 2017 онд 15 нэр төрлийн 2615.3 сая төгрөгөөр давж биелсэн бол 10 нэр төрлийн орлого 366.1 сая төгрөгөөр тасарсан байна. Орлогын төлөвлөгөөнөөс давсан болон тасарсан орлогуудыг нэр төрлөөр авч үзвэл дараах байдалтай байна.

5.6.2.Давсан орлого:

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	Хувь
НИЙТ ОРЛОГО	13554.7	16170.1	2615.3	119.3
Хөрөнгийн орлого	9.1	104.5	95.4	1145.9
Шууд бус орлого	546.7	727.1	180.4	133.0
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	380.0	385.2	5.2	101.4

БУЛГАН АЙМГИЙН ТЕЗ-ИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	254.6	272.5	17.9	107.0
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	65.9	74.2	8.3	112.7
Ашигт малтмалаас бусад байгалийн нөөц ашигласны зөвшөөрөл олгох	130.0	136.6	6.6	105.1
Газрын төлбөр	221.0	305.1	84.1	138.1
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	26.2	51.4	25.2	196.0
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	11859.3	13966.2	2106.9	117.8
Байгалийн ургамал ашигласны төлбөр	1.2	2.1	0.9	173.6
Хувьцааны ногдол ашиг	13.2	38.4	25.2	290.4
Бусад орлого	7.5	16.7	9.2	222.3
Түрээсийн орлого	19.9	24.5	4593.1	123.0
Хүүгийн орлого	0	16.6	16.6	#DIV/0!
Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	20.0	48.8	28.8	243.9

Татварын орлогоор 2017 онд аймгийн төсөвт 18237.1 сая төгрөг төвлөрүүлэхээс 20509.7 сая төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 2272.6 сая төгрөгөөр давуулан биелүүлжээ. Ус рашааны нөөц ашигласны төлбөр 2106.9, газрын төлбөр 84.1, шууд бус орлого 180.5 сая төгрөгөөр харьцангуй их хэмжээгээр давж биелсэн нь орлогыг бодиттой төлөвлөөгүй нь харагдаж байна.

2017 оны усны төлбөр нийт дүнгээр биелж байгаа ч уул уурхайгаас орох усны төлбөрийг дутуу төлөвлөж байна. Тухайлбал: “Цагаан уулын магнит” ХХК 30.9, “Эко алтан заамар” ХХК 30.3, Ориент майнинг инвестмент 7.2 сая төгрөг зэрэг төсөвт төлөвлөөгүй 86.6 сая төгрөгийн орлого оржээ.

Эрдэнэт үйлдвэр 2450.0 сая төгрөгийг төлөвлөснөөс илүү оруулсан бол Бүрэгхангай сумын “Монполимет” ХХК 342.7, “ГБНБ” ХХК 19.6, “Хамтын эх булаг” ХХК 12.4 сая төгрөгийг төлөвлөснөөс дутуу оруулсан байна.

5.6.3.Тасарсан орлого:

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь
НИЙТ ОРЛОГО	5626109.3	5260068.8	-366040.5	93.5
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	4188010.1	4138286.6	-49723.5	98.8
Үйл ажиллагааны орлого	214011.9	128484.2	-85527.7	60.0
Бууны албан татвар	65890	60407.3	-5482.72	91.7
Улсын тэмдэгтийн хураамж	189000	151728.3	-37271.7	80.3
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	145114.5	89827.3	-55287.2	61.9

БУЛГАН АЙМГИЙН ТЕЗ-ИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Бусад татвар	2000	0	-2000	0.0
Ойн нөөц ашигласны төлбөр	331716.4	310734.0	-20982.4	93.7
Нохойн татвар	2500	678.7	-1821.3	27.1
Торгуулийн орлого	402450	355596.1	-46853.9	88.4
Бусад орлого	85416.4	24326.3	-61090.1	28.5

Цалин, хөдөлмөрийн хөлс тэдгээртэй адилтгах орлого 49.7, үйл ажиллагааны орлого 85.5, улсын тэмдэгтийн хураамж 37.2, хог хаягдлын үйлчилгээний хураамж 55.4, торгуулийн орлого 46.8 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

Тасарсан орлого болох торгуулийн орлого 402.5 сая төгрөгөөр төлөвлөн гүйцэтгэлээр 355.6 сая төгрөгийн орлого төвлөрүүлж 46.8 сая төгрөгөөр тасарсан байна. Аймгийн Цагдаагийн газрын бэлэн бус торгуулийн машинаар 2017 онд 543.6 сая төгрөгийн торгууль бүртгэгсэн, торгуулийн орлогыг оруулах талаар тодорхой хариуцсан газар байхгүйгээс орлого тасарч, тооцоогоор торгууль бичигдсэн 200.0 сая төгрөг төсөвт төвлөрөөгүй байна. Тухайлбал: Баяннуур сумын хүү торгуулийн орлогыг оны эхэнд 30.1 сая төгрөгөөр баталж тодотголоор 10.0 сая төгрөг болгон бууруулан баталжээ. Орлогыг анх төлөвлөхдөө 2016 онд 15.0 сая төгрөг бэлэн бус торгуулийн машинаар бичигдсэн торгуулийг орохоор тооцон төлөвлөсөн, 2017 онд 23.4 сая төгрөгийн торгууль бичигдсэн ч 9.1 сая төгрөгийн гүйцэтгэлтэй нийт 29.3 сая зөвхөн нэг сумын торгуулийн орлого орох боломж байна.

5.7.Зардлын бүртгэл, тайлагнал:

5.7.1.ЗАРЛАГЫН ТАЛААР:

Аймгийн төсвийн нийт зарлага 2017 оны жилийн эцсийн байдлаар 57908.9 сая төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 53941.9 сая төгрөгийн буюу 93.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

2017 ОНЫ ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ

Д/д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Эзлэх хувь
1	Аймгийн Засаг дарга	28125.4	24299.5	45.2
2	БСШУсайдын	25151.3	24844.8	46.3
3	БХБсайдын	241.6	241.1	0.4
4	НХХсайдын	162.4	162.4	0.3
5	Эрүүл мэндийн сайдын	4228.4	4213.2	7.8
	ДҮН	57909.1	53941.9	

Аймгийн ТЕЗ-ийн төсвийн зарлагын гүйцэтгэлийг зориулалтаар авч үзвэл нийт зарлагын 45.2 хувь аймгийн Засаг дарга, 46.3 хувийг БСШУСайдын ТЗШ, 7.8

хувийг Эрүүл мэндийн сайдын ТШЗ зарцуулсан байгаа нь нийт зарлагын 99.3 хувийг эзэлж байна.

Төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт, хэмнэлтийг сайдын ТШЗ-ээр авч үзвэл:

Батлагдсан төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 3825.9 сая төгрөгөөр, БСШУСайдын ТШЗ 306.5 сая төгрөгөөр, Эрүүл мэндийн ТШЗ 15.2 сая төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

Орон нутгийн төсвийн нийт зардлыг бүтцээр нь харуулбал:

Үзүүлэлт	Тайлант оны		хэтрэлт хэмнэлт
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	57,764.59	53,944.88	3,819.71
УРСГАЛ ЗАРДАЛ	49,613.03	48,715.12	897.91
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	40,659.82	39,628.17	1,031.65
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	22,137.07	22,002.39	134.68
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,451.55	2,437.70	13.85
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,188.82	5,094.02	94.80
Хангамж, бараа материалын зардал	1169.79	1160.58	9.21
Нормативт зардал	2,112.79	2,101.19	11.60
Эд хогшил, урсгал засварын зардал	592.20	589.07	3.13
Томилолт, зочны зардал	185.12	178.72	6.40
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	360.25	355.39	4.86
Бараа үйлчилгээний бусад зардал	6462.23	5709.11	753.12
Бусад урсгал шилжүүлэг	8615.99	8582.15	33.84
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,545.61	4,299.94	1,245.66
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	2605.95	929.81	1,676.14
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	57764.59	53897.98	3,866.61
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	29,535.79	29,364.14	171.65
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	29535.79	29364.14	171.65
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	20,850.13	22,336.13	(1,486.00)
Орон нутгийн төсвөөс	19,105.18	20,591.18	(1,486.00)
Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	1,744.95	1,744.95	0.00
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	7,378.66	2,197.71	5,180.95
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,656.81	1,999.59	657.22
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	159.85	198.12	(38.27)

БУЛГАН АЙМГИЙН ТЕЗ-ИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	1,819.48	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	1,944.25	

Дээрх хүснэгтээс харахад нийт зардалд бараа үйлчилгээний зардал 39626.6 сая төгрөг буюу 73.5 хувь, хөрөнгийн зардал 4299.9 сая буюу 7.9 хувь, татаасын зардал 34.5 сая төгрөг буюу 0.06 хувь, урсгал шилжүүлэг 9052.5 сая төгрөг буюу 16.8 хувийг тус тус эзэлж байна. 2017 оны төсвийн хэтрэлт хэмнэлтийг зардлын зүйл ангиар авч үзвэл:

- Цалин, шимтгэл, тогтмол зардал, хоол зэрэг нормативт зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал, хангамж, бараа материалын зардал зэрэг урсгал зардлуудыг батлагдсан төлөвлөгөөнөөс 1033.0 сая төгрөгөөр, нийгэмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн зардал нь 33.8 сая төгрөгөөр, хөрөнгийн зардал 1245.6 сая төгрөгөөр дутуу зарцуулагдсан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны нийт зардлыг өмнөх онтой харьцуулан сумдаар харуулбал:

Сумын нэр	Өмнөх	Тайлант он	Өссөн буурсан	Тайлант онд эзлэх хувь
Булган аймаг	17259.9	17305.2	45.3	32.1
Баян-Агт	1748	1790.7	42.7	3.3
Баяннуур	1335.2	1363.4	28.2	2.5
Бугат	1169.9	1272.5	102.6	2.4
Булган	6658.5	7604.2	945.7	14.1
Бүрэгхангай	1714.3	1618.6	-95.7	3.0
Гурванбулаг	1730.2	1911.4	181.2	3.5
Дашинчилэн	1787.6	1837.9	50.3	3.4
Могод	1563.8	1635.1	71.3	3.0
Орхон	1527.9	1340.3	-187.6	2.5
Рашаант	1931.3	2141.9	210.6	4.0
Сайхан	1730.9	1848.8	117.9	3.4
Сэлэнгэ	2124.2	2476.2	352	4.6
Тэшиг	2158.6	2141.8	-16.8	4.0
Хангал	1047.5	1180.6	133.1	2.2
Хишиг-Өндөр	1763.5	1797	33.5	3.3
Хялганат	1827.8	2004.7	176.9	3.7
Хутаг-Өндөр	2421.1	2671.6	250.5	5.0
Нийт	51500.2	53941.9	2441.7	100

Сум тус бүрээр авч үзвэл Бүрэгхангай, Орхон, Тэшиг 16.8-187.6 сая төгрөгөөр буурч бусад сумдын зардал 28.2-250.5 сая төгрөгөөр өсчээ.

5.7.2.Нэмэлт санхүүжилтийн зарцуулалт:

Нэмэлт санхүүжилтийн нэгтгэсэн тайлангаар тайлант онд 2362.8 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж 2269.8 сая төгрөг зарцуулж 92.9 сая төгрөгийг аймаг, сумын ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн байна.

5.7.3.Тусгай шилжүүлэгийн зарцуулалт:

Төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1-д “ Аймаг, Нийслэлийн Засаг дарга Засгийн газрын дараах чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлнэ.” гэж заасан. Үүнд:

- Ерөнхий боловсрол
- Сургуулийн өмнөх боловсрол
- Соёлын үйлчилгээ
- Эрүүл мэнд
- Газрын харилцаа
- Хүүхэдийн хөгжил, хамгаалалын үйлчилгээ
- Нийтийн биеийн тамир

Төсөвт батлагдсан тусгай зориулалтын шилжүүлгийн 29535.7 сая төгрөгийг төсвийн хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-д заасны дагуу санхүүжүүлсэн байна.

Гүйцэтгэлээр 29642.3 сая төгрөг буюу төлөвлөгдсөн нийт зардал 99.5 хувийн гүйцэтгэлтэй байна. БХБСайд 67.2 улсын төсөвт төвлөрүүлдэг орлого, 0.4 төсвөөс хэмнэгдэж төвлөрүүлсэн дүн, БСШУСайд 142.8 сая төгрөгөөс 139.0 төсвийн хэмнэлт, 3.8 нэмэлт санхүүжилт, ЭМСайд 32.2 сая төгрөг, ХНХ сайд 1.2 сая төгрөг төсвийн хэмнэлтээс нийт 243.4 сая төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Тусгай шилжүүлэгтэй холбоотой хөрөнгийн задаргаа

Үзүүлэлт	2017	ЭМС-ын сайд	ХАХНХ-ын сайд	БСШУ-ын сайд	БХБсайд
Мөнгөн хөрөнгө	42.6	42.6	-	-	-
Авлага	48.7	10.9	17.6	20.2	-
Нөөцийн бараа	3349.8	440	5.1	2867.3	37.4
Үндсэн хөрөнгө	54723.4	4268.3	589	49540	326.1
Нийт хөрөнгийн дүн	58107.1	4721.5	594,1	52428	363.5
Өр төлбөр	21.7	9.2	1.3	11.2	-

Хүснэгтээс харахад: нийт хөрөнгөд мөнгөн хөрөнгө 0.07, авлага 0.08, бараа материал 5.8, үндсэн хөрөнгөс 94.1 хувийг эзлэж байна..

Зардлын данстай холбоотой дараах нийтлэг зөрчлүүд илэрлээ.

- Булган сумын 1 дүгээр сургууль: Тус сургуулийн захиралын тушаалаар хичээл үйлдвэрлэлийн зардлаас нийт 7860.8 мянган төгрөгийн буцалтгүй тусламж, шагнал, бэлэг авахад зарцуулсан.

- Булган сумын 2 дугаар сургууль: Үдийн цай хөтөлбөрийг Майдар царам ХХК-аар гүйцэтгүүлдэг бөгөөд тайланд онд 103227 хүүхэд өдөрт 61936.2 мянган төгрөг олгосон байна. Гэвч гэрээний дагуу урьдчилгаа олгохдоо бэлэн мөнгөний хүсэлтээс бус нэхэмжлэхээр олгодог, үлдэгдлийн тухайн сарын нийт дүнгээр нэхэмжилдэг, 12 дугаар сарын шилжүүлгийг төрийн сангийн гүйлгээ хаахтай холбоотойгоор 20-оос нийт хүүхэд хамрагдахаар гүйлгээ хийн тооцоо нийлсэн актаар үлдэгдэл зөрүүгүй гэж тайлагнасан нь 20-оос хойшхи гүйцэтгэл эрсдэл агуулж байна.
- Орхон сумын сургууль: Нормын хувцас зөөлөн эдлэлийн зардлаас 571.8 мянган төгрөгөөр хоол хүнсний материал худалдан авч Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу зардлыг бүлэг хооронд зохицуулалт хийлгүйгээр зарцуулсан зөрчил илэрлээ.
- Орхон сумын цэцэрлэг: Нийт зардлыг хэтрүүлээгүй ч шатахууны зардлыг 82.3, БҮТЭЗ-ыг 1388.1, урсгал засварын зардлыг 1999.5, хичээл үйлдвэрлэлийн зардлыг 449.1 мянган төгрөгөөр хэтрүүлэн түлш халаалтын зардлаас санхүүжүүлэн зүйл анги, бүлэг хооронд шилжүүлэн зарцуулсан.
- Өмнөх онд Аймгийн ЗДТГ 65.0 сая төгрөгөөр орон сууц худалдан авч 28.0 сая төгрөгийн төлж жилийн эцсийн санхүүгийн тайланд 37.0 сая төгрөгийг өглөг үүсгээгүй үнэ төлбөргүй үндсэн хөрөнгө дансанд бүртгэсэн. 2017 онд үлдэгдэл 37.0 сая төгрөгийг төлж тайланд бараа үйлчилгээний бусад зардалд шууд бичиж тайлагнасан.
- Аймгийн ЗДТГ-ын албан хаагчдад орон байраар хангах, орон сууцны дэмжлэгийг 2017 оны 03 дугаар сарын 22-нд 30.0, 2017 оны 06 дугаар сарын 05-нд 10.0 сая төгрөгийг түлш халаалтын зардлын хэмнэлтээс төсвийн хуваарьт өөрчлөлт оруулан 4 албан хаагчдад 40.0 сая төгрөгийг олгосон нь зөрчил нь Төсвийн тухай хуулийн 42.7 дахь “Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно.” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч болон түүний харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүнгийн талаар:

ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн аймгийн орон нутгийн байгууллагууд төсөл сангийн санхүүгийн тайланд 100 хувь аймгийн аудитын газрын аудитор нар, зарим тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагууд болон ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайланд гэрээгээр хараат бус аудитын компаний аудитор нар аудитыг хийсэн. Аудит нийт 203 байгууллага хамруулж 149 байгууллагыг түүвэрт хамруулж, 3 байгууллагад итгэл үзүүлэн, 1 байгууллагад аудит хамрагдаагүй, 50 байгууллагад дүгнэлт гаргаснаас 4 тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт, 7 байгууллагад “татгалзсан” санал дүгнэлт өгсөн байна.

Булган аймгийн аудитын газар нийт 201 байгууллагад аудит хийхээр төлөвлөснөөс 2017 онд шинээр байгуулагдан үйл ажиллагаа явуулж эхэлсэн 12 жилийн 3-р сургууль, Булган сумын харьяа “Насан туршийн боловсрол”-ийн хоёр тайланг аудитын түүвэрт хамруулснаар гүйцэтгэлээр 203 байгууллага гарсан байна.

Сүүлийн 2 жил үйл ажиллагаа явуулаагүй, тайлан баланс гаргаагүйгээс татан буулгахаар шийдвэрлэж байгаа Бугат сумын “Элгэн бугат” ОНӨААТҮГ аудитад хамрагдаагүй болно.

Аудитад хамрагдсан байгууллагуудаас өөрсдийн хүчээр бүх түүвэрт хамрагдсан байгууллагууд болон бие даан дүгнэлт гаргасан 28 байгууллагад баталгаажуулах аудит хийж хувийн аудитын компаниар 22 байгууллагад бие даан дүгнэлт гаргуулан ажиллалаа.

Аудитаар нийт 3814.4 сая төгрөг илэрсний 2586.7 сая төгрөгийн алдаа зөрчил аудитын явцад залруулсан, 2.7 сая төгрөгт төлбөрийн акт бичиж, 52.9 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага өгч, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 856.5 сая төгрөгийн 113 зөвлөмж, 315.5 сая төгрөгийн албан тушаалтанд хариуцлага тооцох санал тус тус хүргүүлээ.

Аудитаар хязгаарлалттай болон татгалзсан дүгнэлт авсан байгууллагууд, дүгнэлтийн шалтгааныг хүснэгтээр харуулбал:

“Хязгаарлалттай” санал дүгнэлт авсан байгууллагын жагсаалт

№	“Хязгаарлалттай” дүгнэлт авсан байгууллага	“Хязгаарлалттай” санал, дүгнэлтийн шалтгаан
1	Булган сумын хот тохижилт	Жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор соёл амралтын цэцэрлэгт хүрээлэнгийн хөрөнгийн тооллого хийгээгүй санхүүгийн тайлантай бараа материалын тайлан нь бүх дансаараа зөрүүтэй илэрхийлсэн.
2	Баяннуур сумын сургууль	Бараа материалын тодруулгын дүн санхүүгийн тайлангийн дүн зөрүүтэй, тооллогыг хууль, журам, стандартын дагуу бүрэн хийгээгүй.
3	Орхон сумын сургууль	Өөрийн орлогыг санхүүгийн тайланд тусгаж тайлагнаагүй, зардлыг бүлэг хооронд зөвшөөрөлгүй шилжүүлэн зарцуулсан, жилийн эцсийн тооллогыг хууль, журам, стандартын дагуу бүрэн хийгээгүй.
4	Орхон сумын ЭМТ	Эмийн тайланг 1, 2, 8, 9 дүгээр сараас бусад сард Үндэсний статистикийн газрын даргын 2002 оны 6-р сарын 18-ний 171/111 тоот тушаалын хавсралтаар баталсан НХМаягт БМ-9 дүгээр маягтаар гаргаагүй, нийт дүнгээр орлого зарлагын дүнг бичсэн, эмийг нэр төрлөөр бус нийт дүнгээр тайланд зарлагдсан, няравийн тайлангийн орлого зарлагаас зөрүүтэй бүртгэдэг, дууссан эмээс зарлагдаж хасах дүнтэй үлдэгдэлтэй эмийн тайлан гаргасан байна.
5	Баяннуур сумын Орон нутгийн нэгтгэсэн тайлан	2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар сумын төсөвт байгууллагуудаас ЗДТГ, Эрүүл мэндийн төвд санал дүгнэлт өгөхөөс татгалзсан, ерөнхий боловсролын сургууль хязгаарлалттай дүгнэлт авсан байна. Сумын ЗДТГ аудитын дүгнэлт гаргах хуваарьт хугацаа буюу 01 дүгээр сарын 26-29 -нд нягтлан бодогч тайлангаа баталгаажуулаагүй хөрөнгийн үлдэгдэлд тулгалт хийгээгүй, Төрийн аудитын тухай хуулийн 21.1 дэх заалтыг зөрчиж, санхүүгийн тайлангийн “Тохиолдсон байх, Иж бүрэн байх, Үнэн зөв байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна
“Татгалзсан” санал дүгнэлт авсан байгууллага		

№	“Санал, дүгнэлт өгөхөөс татгалзсан” авсан байгууллага	“Санал, дүгнэлт өгөхөөс татгалзсан” санал, дүгнэлтийн шалтгаан
1	Баяннуур сумын ЗДТГ	Нягтлан бодох бүртгэлийн хөтлөлтийг бүрэн хийгээгүйгээс үнэн зөв санхүүгийн тайлан бэлтгэх боломжгүй, санхүүгийн тайланд нөлөөлөхүйц аудитын нотлох баримт байхгүй тул санал дүгнэлт өгөхөөс татгалзсан.
2	Баяннуур сумын ЭМТ	Нягтлан бодох бүртгэлийн хөтлөлтийг бүрэн хийгээгүйгээс үнэн зөв санхүүгийн тайлан бэлтгэх боломжгүй, санхүүгийн тайланд нөлөөлөхүйц аудитын нотлох баримт байхгүй тул санал дүгнэлт өгөхөөс татгалзсан.
3	Хишиг-Өндөр сумын ЭЭС	Анхан шатны бүртгэл, журнал хөтлөөгүй.
4	Могод сумын ЭЭС	Анхан шатны бүртгэл, журнал хөтлөөгүй.
5	Гурванбулаг сумын ЭЭС	Анхан шатны бүртгэл, журнал хөтлөөгүй.
6	Баяннуур сумын ЭЭС	Анхан шатны бүртгэл, журнал хөтлөөгүй.
7	Орхон сумын ЭЭС	Анхан шатны бүртгэл, журнал хөтлөөгүй.

5.7.4.Төсөл сангуудын зарцуулалтын талаар:

Аймгийн ОНХС: Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээний ажлуудыг аймгийн ИТХ-ын 2016 оны 3 дугаар хуралдааны 03/03 тоот тогтоолын хавсралтаар хөрөнгө оруулалтын 4 ажилд 668.0, тоног төхөөрөмжийн 2 ажилд 55.0, хөтөлбөр төсөл арга хэмжээний 4 ажилд 238.0 сая төгрөгийн нийт 961.0 сая төгрөгийг баталуулж, 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн IV/04 тоот тогтоолын хавсралтаар хөрөнгө оруулалтын 6 ажилд 788.8, тоног төхөөрөмжийн 2 ажилд 55.0, хөтөлбөр төслийн 4 ажилд 238.0 сая төгрөг буюу нийт 1081.8 сая төгрөгийн санхүүжилт олгохоор тодотгол хийгдэн баталж өмнөх тогтоолоос хөрөнгө оруулалтын 2 ажлын 120.8 сая төгрөгийн санхүүжилтийг нэмэгдүүлж нийт 12 ажил хийгдэхээр баталсан байна.

2017 онд ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэх 12 ажилд өмнөх оны үлдэгдэл 157.9 сая төгрөг дээр нийт 1029.1 сая төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 1040.8 сая төгрөгийг зарцуулж оны эцэст 146.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй, нийт ажлын гүйцэтгэл 92.8 хувьтай гарч сумдад шилжүүлэх морин хуурын үнэ 3.2 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй тайлагнажээ.

Санхүүгийн тайлангийн горим сорилын түүвэрлэлтээр “Эрүүл мэндийн хөтөч” хөтөлбөр, “Оюунлаг Булган” хөтөлбөр, аймгийн баяр наадмын ажил гэсэн 3 дэд хөтөлбөрийн гүйцэтгэлийг сонгон авч гүйцэтгэлээ.

Үүнд: “Эрүүл мэндийн хөтөч” хөтөлбөрийн ажилд 17.5, “Оюунлаг Булган” хөтөлбөрийн хэрэгжилтэнд 34.1, аймгийн баяр наадмын ажилд 50.0 сая төгрөгийг тус тус санхүүжүүлж ажилласан боловч ОНХС-гаар хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээний ажлуудын хэрэгжилт санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт сул, бараа материал болон үндсэн хөрөнгийг тухайн байгууллага тайлан бүртгэлдээ тусгаагүй зөрчлүүд илэрч байна.

Тухайлбал: Эрүүл мэндийн газар нь аймгийн ЗД-ын 2017 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/136 тоот захирамжын дагуу “Эрүүл мэндийн хөтөч” хөтөлбөрийн төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх сургалт үйл ажиллагааг зохион байгуулан ажилласан боловч ОНХС-гаас санхүүжүүлсэн 17.5 сая төгрөгийн материалыг, мөн

29.9 сая төгрөгийн “В”, “С” вирусн лабораторийн хэрэгсэлийг нийт 47.5 сая төгрөгийн тоног төхөөрөмж, материалыг байгууллагын данс бүртгэл тайланд тусгаагүй, дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн хяналт тавьж ажилласан тухай ажлын тайлан байхгүй, эм болон эмийн хэрэгслэл тараасан тараалтын баримт дутуу, “Эрүүл мэндийг дэмжигч” болзол уралдааны 1.5 сая төгрөгийн ажил хийгдээгүй байхад санхүүжилтийг олгосон, БСУГ нь 5.0 сая төгрөгийн ном худалдан авч 16 сумын соёлын төвд тараасан гэх боловч Баян-Агт сумын соёлын төв 0.25, Могод сумы соёлын төв 0.25, Бүрэхангай сумын соёлын төв .0.25, нийт 3 сум 0.75 сая төгрөгийн ном орлогод аваагүй, санхүүгийн тайлан бүртгэлдээ тусгаж тайлагнаагүй, зэрэг зөрчлүүд илэрлээ.

Цаашид ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээг ОНХС-гийн зарцуулах журамын 4.2, 4.5, 9.4 дэх заалтуудыг хэрэгжүүлэх, хяналт тавьж ажилласан тухай ажлын хэсгийн тайлан, ажлын хэрэгжилтийг тайлагнаж худалдан авсан бараа материал болон үндсэн хөрөнгийг холбогдох албан газруудын тайлан балансад бүртгүүлэх төсөл арга хэмжээг хариуцан зохион байгуулж байгаа албан хаагчдын ажлыг сайжруулах, ОНХС-гийн хөрөнгийг арвилан хэмнэлттэй, үр дүнтэй зарцуулж байх шаардлагатай байна.

Сумдын ОНХС: ОНХНС-гаас Булган аймгийн 16 суманд 2017 онд 567.5 сая төгрөгийн санхүүжилт олгохоор баталж 553.9 сая төгрөг санхүүжилт олгосон байна.

ОНХНС-гаас олгогдох санхүүжилтийн дагуу аймгийн ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 05 -ны өдрийн хуралдааны 03/03 тоот тогтоолоор 2017 онд сумдын орон нутгийн хөгжлийн санд олгох санхүүгийн дэмжлэгийг 567.5 олгохоор баталсныг аймгийн ИТХ төсвийг 1 удаа тодотгон баталсан, аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 04 -ний өдрийн 06/01 тоот тогтоолоор сумдын орон нутгийн хөгжлийн санд олгох санхүүгийн дэмжлэгийг 553.9 сая төгрөг олгохоор тодотгожээ.

Сумдад олгохоор төлөвлөсөн санхүүжилт тооцсон.

№	Сумдын нэр	Баталсан төсөв	Санхүүжилт олгосон дүн
1	Баян-Агт	47.2	47.2
2	Баяннуур	11.4	11.4
3	Бугат	10.1	10.1
4	Булган	66.4	52.9
5	Бүрэгхангай	42.2	42.2
6	Гурванбулаг	44.8	44.8
7	Дашинчилэн	13.8	13.8
8	Могод	43.1	43.1
9	Орхон	43.9	43.9
10	Рашаант	44.2	44.2
11	Сайхан	13.9	13.9
12	Сэлэнгэ	52.7	52.7
13	Тэшиг	26.8	26.8
14	Хангал	45.9	45.9
15	Хишиг-Өндөр	38.8	38.8
16	Хутаг-Өндөр	21.7	21.7
	Нийт	567.5	553.9

Сумдын ОНХС нь 2017 оны эхний үлдэгдэл 741.6 сая төгрөг дээр ОНХНС-гаас санхүүжүүлсэн 553.9 сая төгрөг нийт 1295.5 сая төгрөгийн эх үүсвэртэйгээр 175 төсөл арга хэмжээ хэрэгжүүлсэн байна.

Сумдын орон нутгийн хөгжилийн сангаас илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл:

Сумдын орон нутгийн хөгжлийн сангаас Тэшиг, Хангал, Булган сум Цагдаагийн бэлэн бус торгуулийн машин худалдан авахаар 10.3 сая төгрөг баталж 10.2 сая төгрөгийн санхүүжилт олгож худалдан авсан, мөн Хишиг-өндөр сум 2.5 сая төгрөгөөр ахмадын кабинетад массажны тоног төхөөрөмж, Могод сум 1.4 сая төгрөгөөр олон нийтийн цагдаагийн цалин олгосон, 2 сая төгрөг автомашины засвар, 1 сая төгрөгөөр Соёлын төвийн дуу гаргалтын тоног төхөөрөмж, Сайхан сум Машины сэлбэгт 2 сая төгрөг, Сийлбэртэй гэр 17.5 сая төгрөг, Онцгой байдлын багаж 1.3 сая төгрөгөөр тус тус худалдан авсан нь Төсвийн тухай хуулийн 60.3-д “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно”, 60.3.1-д “Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр арга, хэмжээ” гэж заасныг зөрчсөн зөрчилд дахин зардлыг санхүүжүүлэхгүй байхаар зөвлөмж хүргүүлээ.

Булган сумын ОНХС-аас Хот тохижилтийн ангид нийтийн эзэмшлийн зориулалттай олон үйлдэлт трактор худалдан авахаар 34.9 сая төгрөг баталж худалдан авалт хийсэн ч дагалдах хэрэгсэл болох ногоон байгууламж услах тоног төхөөрөмж, давс цацах зориулалттай тоног төхөөрөмж дутуу нийлүүлсэнээс 17.4 сая төгрөгийн санхүүжилт олгож үлдэгдэл 17.5 сая төгрөгийг өглөгт тусгаагүй, хөрөнгийг орлогод аваагүй нь НББ-ийн тухай хуулийн 14.4 дэхь заалтыг зөрчиж байна. Мөн тракторын тоног төхөөрөмж нь зах зээлийн үнээс өндөр байна.

Байгаль хамгаалах сан: Булган аймгийн Байгаль хамгаалах сан 3717.6 сая төгрөгийн санхүүжилт авахаас 521.4 сая төгрөгөөр дутуу буюу 3196.2 сая төгрөгийн санхүүжилт авч, үнэт цаасны орлого 7.1, бусад орлого 1.3 нийт 8.4 сая төгрөгөөр эх үүсвэрийг нэмэгдүүлж нийт 3204.5 сая төгрөгнөөс тухайн оны 33 төсөл хөтөлбөр арга хэмжээнд 2941.9, урьд оны 5 төсөл, хөтөлбөр арга хэмжээнд 254.3 сая төгрөгийг зарцуулж дансны үлдэгдэлгүй байна.

Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалтыг төлөвлөхдөө зураг, төсөв, эдийн засгийн тооцоолол, хэрэгжүүлэх ажлын төлөвлөлт, хөтөлбөргүйгээр нийт 6 төсөл арга хэмжээнд 1638.8 сая төгрөгийг, Төсвийн тухай хуулийн 29.4 дэхь заалт, мөн Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлангах журам”-ыг тус тус зөрчин 5 төсөл, хөтөлбөр арга хэмжээнд 61.5 сая төгрөгийг зарцуулахаар аймгийн ИТХ-аар батлуулж, дээрх төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн ажилласан байна. Төсвийн тухай хуулийн 42.7-д “Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно” гэсэн заалтыг зөрчин хэзээ, хэрхэн, юунд зарцуулах нь тодорхойгүй шаардлагатай үед зарцуулах зардалд 78.2 мянган төгрөгийг баталж 12.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

“Булган жимс жимсгэнэ” хөтөлбөрийн хүрээнд 414.4 сая төгрөгийн суулгац, 213.1 сая төгрөгийн хашаа, 236.3 сая төгрөгийн худаг, 57.5 сая төгрөгийн усалгааны тоног төхөөрөмж, 35.0 сая төгрөгийн эрчим хүчний трансформатор, 29.9 сая төгрөгийн усалгааны систем, нийт 986.3 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэл тайланд тусгахаас Баян-Агт, Баяннуур, Бугат, Булган, Бүрэгхангай сумд нийт 146.3 сая төгрөгийн суулгац, Баяннуур, Бугат, Булган сум нийт 109.5 сая төгрөгийн худаг, Сэлэнгэ сум 10.0 сая төгрөгийн хашаа, Бугат, Сайхан сум 5.0 сая төгрөгийн хашааг тус тус бүртгэл тайланд тусгаагүй байгаа зөрчилд албан шаардлага бичлээ.

Байгаль хамгаалах сан оны эхэнд ойжуулалтын 70.7 сая төгрөгийн өглөг, сумдаас авах ойжуулалтын авлага 247.0 сая төгрөгийн авлагатай байснаас тайланд жилд 2016 оны ойжуулалтын өглөг 31.8 сая төгрөгийн өглөг, үнэт цаасны 7.1, бусад 1.3 нийт 8.4 сая төгрөгийн авлага тус тус барагдаж оны эцэст 38.7 сая төгрөгийн өглөг, 245.8 сая төгрөгийн авлагатай тайлагнасан байна. 2017 онд байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр гүйцэтгэсэн төсөл, хөтөлбөрүүдээс ойжуулалтын санхүүжилтын үлдэгдэл 48.7 сая төгрөгийг өглөгөөр тусгаагүй нь Төсвийн тухай хуулийн 6.2.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.3-д заасан заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй зөрчилд зөвлөмж хүргүүлжээ.

Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр Баян-Агт суманд хийгдсэн гүний худаг байршилыг ХХААГазар, сумдын удирдлагууд болон гүйцэтгэгч компанийн буруугаас өөр газарт гаргасан зөрчил илэрсэн. Хяналт муугаас захиалагчтай байгуулсан гэрээ, техникийн тодорхойлолтыг зөрчиж сумын төвөөс урд зүгт 5 км-ын зайтай Хагийн нуур орчимд гаргах худгийг зүүн урд зүгт 1-2 км-ыг зайтай далангийн урд гаргаж малчин иргэдэд хохирол учруулж, төсвийн хөрөнгийг үр дүнгүй зарцуулжээ.

Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр 2016 онд 173.5 сая төгрөгийн 400 ширхэг, 2017 онд 164.8 сая төгрөгийн 400 ширхэг хогын савыг Булган сумын айл өрх, албан газруудад байрлуулж хэрэгжүүлсэн боловч бодит байдал дээр айл өрхүүд хогийг 2 төрлийн хогийн саванд дахин ашиглах болон бусад хогоор ангилан хийхгүй, мөн ангилагдсан хогийг Тохижилт үйлчилгээний анги нийлүүлж ачаад хогийн төвлөрсөн цэгт хаяж байгаа нь хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр үр дүн, үр өгөөжгүй байна. Энэ нь Байгаль хамгаалах тухай хуулийн 21.3.2, Хог хаягдлын тухай хуулийн 9.3.1, 9.3.4, 9.3.6, 9.3.9, заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй зөрчилд хог, хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж хаях ажлыг иргэдэд сурталчилан зохион байгуулах сургалт сурталчилгааны ажлыг шат дараатай хийх, мөн уг ажлыг гардан хэрэгжүүлэх тохижилт үйлчилгээний анги хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт ачиж тээвэрлэхдээ хогыг ангилан ялгалалт дээр хяналт, хариуцлага тооцдог байх ажлыг судлан хэрэгжүүлэх, зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажиллах албан шаардлага хүргүүлжээ.

Чацарганы суулгац: “Хаан жимс эс би ти” ХХК 366187.5 мянган төгрөгийн өртөгтэй суулгацыг хавар 96875 ширхэг, намар 96875 ширхэг нийт 193750 ширхэг суулгацыг нийлүүлэхээр, “Хар хорин ” ХК 387500.0 мянган төгрөгийн өртөгтэй суулгацыг хавар 54390 ш, намар 139360 ш нийт 193750 ширхэг суулгацыг нийлүүлж 2017 онд нийт суулгацын өртөгийн 40 хувийг 2 үе шаттайгаар үлдэгдэл 60 хувийг 2018 онд санхүүжүүлэхээр тус тус гэрээ байгуулжээ.

Хөтөлбөрийн хэрэгжилтэнд орон нутгийн удирдлагуудын хяналт, шаардлага сул байна. Тухайлбал: Суулгацын захиалгыг тооцохдоо сумдуудаас ирүүлсэн

хүсэлтийг харгалзан үзээгүйгээс Бүрэгхангай суманд 2000, Гурванбулаг сум 275 ш суулгацыг илүү нийлүүлсэн, Хишиг-Өндөр сум намар хүлээж авсан 20000 ш суулгацыг бүлүүд хүлээж авсан боловч одоог хүртэл тариалалтыг хийгээгүй, Чацаргана тариалах бүлүүдэд суулгацыг хүлээлгэн өгсөн боловч зарим сумдууд бүлүүдтэй гэрээ байгуулаагүй байна./Хишиг-Өндөр сум, Булган сум, Тэшиг сум гэх мэт/, Зарим сумд чацаргана тариалах талбайг газар зохион байгуулалтын төлөвлөгөөд тусгаагүй, бүлүүдэд хуваарилж өгсөн газрыг хуулийн дагуу эзэмшүүлээгүй, Сумдуудад 2018 онд хавар, намар нэмж тариалах тооцоо судалгаа одоо хүртэл байхгүй байна, Булган суманд иргэдэд хүлээлгэж өгсөн суулгацаас нийт 685 ш суулгацыг иргэн болон бүлүүдэд хүлээлгэн өгсөн нь тодорхойгүй дутагдуулсан.

Аймгийн хөрөнгө оруулалт: Аймгийн ИТХ-ын 2017 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 11 төсөл, арга хэмжээ 2286.7 сая төгрөгөөр батлагдаж гүйцэтгэлээр 9 төсөл, арга хэмжээнд 1447.4 сая төгрөгийн санхүүжилтыг олгож 57.4 сая төгрөг хэмнэгдэж, 3 төсөл арга хэмжээний 781.9 сая төгрөгийн ажлыг 2018 онд санхүүжүүлэхээр баталсан. Зарим ажлаас дурьдвал:

1. Булган сумын төвийн хатуу хучилттай авто замын өргөтгөл, шинэчлэлийн ажилд 491.3 сая төгрөг батлагдаж “Сэлэнгэ есөн эрдэнэ” ХХК шалгарч 439.3 сая төгрөгийн ажил гүйцэтгэж, 52.0 сая төгрөгний ажил дутуу, улсын комисс хүлээж аваагүй байна.
2. Аймгийн баяр наадмын талбайг шинэчлэн засварлах ажилд 252.8 сая төгрөг батлагдсан боловч ажил эхлээгүй учир 2018 онд санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн.
3. Рашаант, Тэшиг, Хишиг-Өндөр сумдын ЗДТГ-ын автомашиныг шинэчлэх 120,0 сая төгрөг батлагдаж эрх шилжиж санхүүжилтыг 100 хувь олгож Рашаант Ланд-100 маркийн 2006 оны авто машиныг “ЭЙЧ ТИ АР” ХХК-иас 40.0, Тэшиг Ланд-100 маркийн авто машиныг “БЭЗБ” ХХК-иас 40.0, Хишиг-Өндөр Ниссан потрол маркийн 2010 оны авто машиныг “Орхон нүнжиг” ХХК-иас 39.3 сая төгрөгөөр авсан
4. Булган сумын төвийн гэрэлтүүлгийн өргөтгөл, шинэчлэлийн ажил 477.1 сая төгрөг батлагдсан боловч ажил эхлээгүй
5. Булган сумын ЗДТГ-ын байрны гадна засварын ажилд 96.7 сая төгрөг батлагдсанаас 95.0 сая төгрөгийн гүйцэтгэл гарч 1.6 сая төгрөг хэмнэгдсэн.

Аймгийн авто замын сан: Булган аймгийн авто замын сан “Булган сумын зам засвар арчилалтын ажлыг чанартай хийж гүйцэтгэх” эрхэм зорилго, эрхлэх асуудлын хүрээнд дараах үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

Авто замын сан нь 2017 оны эхэнд 203.2 сая төгрөгний үлдэгдэлтэй, АТБӨЯХА татвараас 254.6, зам ашигласаны төлбөр хураамж 80.0 сая төгрөгний эх үүсвэр бүрдүүлэхээр төлөвлөж үйл ажиллагааны болон зам ашигласаны хураамжаас 62.6, АТБӨЯХА татвараас 245.9 сая төгрөг төвлөрүүлж, замын сангийн төсөл арга хэмжээнд 422.7 сая төгрөг зарцуулж 88.9 сая төгрөгний үлдэгдэлтэй байна. Авто замын сангийн хөрөнгийг аймгийн 2017 оны авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтын дагуу зарцуулсан байна. Үүнд:

Булган сумын авто зам, замын байгууламжийн шинэчлэлийн инженерийн зураг төсөв боловсруулах ажлын Зураг төсвийн үнэ 34.2 сая төгрөгийг “Тарваченбүүлэн” ХХК шилжүүлсэн бүртгэлгүй, Булган-Орхон сумын чиглэлийн хатуу хучилттай замын зураг төсвийн үнэ 10.0 сая төгрөгийг “Гео зураглал” ХХК шилжүүлж авлага үүсгээгүй, ажил эхлээгүй, Булган сумын авто зам, зам засварт 25.0 сая төгрөгийг аймгийн ЗД-ын шийдвэрээр Булган сум руу эрх шилжсэн юу хийсэн тодорхойгүй, тайлан аваагүй, зогсоолын ажилд нийт 333.7 сая төгрөг зарцуулж халуун ус, МСҮТ, ГХБХБГ, Жаран цайны газар зогсоолын ажлыг “Цонхот” ХХК 73.4, 1-р 12 жил зогсоол “Бүлээн оргил” ХХК 92.9, 4-р цэцэрлэг, 9-р байрны зогсоолыг “Булган барилга” ХХК 77.7, Монос эм сан, Од дэлгүүрийн зогсоолыг “Талст билэг” ХХК 62.8 сая төгрөгөөр хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулж ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

6. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга:

Булган аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илэрээгүй, менежментийн захидлаар 5 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлсэн. Хэрэгжилтийг тооцон хариу албан бичгээр ирүүлсэн байна.

7. САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ:

Булган аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Булган аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, төсвийн гүйцэтгэлийн тайлан, бусад илчлэл тодруулагад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй үнэн зөв, шударга илэрхийлсэн тул “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.АНХБАЯР
Ж.ЭНХЦООДОЛ

БЭЛТГЭСЭН:
АХЛАХ АУДИТОР

П.СОДНОМ

